



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зардлын төсвийн
гүйцэтгэл**

**Сонгуулийн зардлын төсвийг
зориулалтын дагуу зарцуулжээ.**

2016 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Баян –Өлгий аймгийн Аудитын газар	Товчилсон үгийн тайлбар3
Аймгийн Тэргүүлэх аудитор (Х.Бекен)	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4
Аудитын менежер (Х.Женисбек)	Бүлэг 1
Ахлах аудитор (нэрийг оруулах)	(Сонгуулийн зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.)
Шинжээч (Ж.Назгүл)	Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл5
2016 оны 01 дугаар сар	Дүгнэлт.....
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70423073 дугаарын утас70422954 дугаарын факсаар харилцана уу	Зөвлөмж.....
ХАЯГ:	Холбогдох байгууллагын санал:
(Аймгийн ЗДТГазар 107 тоот өрөө)	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
	Саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвөлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Энэхүү аудитын зорилт нь Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтан болон Улсын Их Хуалд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитад аймгийн Сонгуулийн хороо, болон бүх сумуудын сонгуулийн хорооны санхүүгийн баримт бичиг, холбогдох бусад мэдээ судалгаа хамрагдав.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашигласан болно. Үүнд:

- Байгууллагуудын санхүүгийн баримт материалыг шалгах
- Санхүүгийн бүртгэлтэй холбоотой туслах дэвтэр, журнал, ерөнхий дэвтрийг шалгах
- Ажилтнуудаас асууж тодруулах, лавлах

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу дэмжлэг болох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг-1

Дүгнэлт: Аймгийн сонгуулийн хороо төсвөө зориулалтын дагуу зарцуулжээ.

Танилцуулга

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зардлын төсвийг төсвийн гүйцэтгэл.

*Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зардлын төсвийг
зориулалтын дагуу зарцуулжээ.*

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос Баян-Өлгий аймгийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулан явуулахад нийтдээ 349835.2 мянган төгрөгийн төсөв хуваарилжээ. Гүйцэтгэлээр 338355.6 мянган төгрөгийг зарцуулж, төсвөө 11479.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэгдсэн 11479.6 мянган төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд төвлөрүүлжээ.

СЕХорооноос хуваарилагдсан 349835.2 мянган төгрөгт 18 нэр төрлийн зардал төсөвлөгдсөнөөс саналын хуудас устгахад 1000.0 мянган төгрөг, тогтоол протокол маягт хэвлүүлэхэд 250.0 мянган төгрөг, сургалтын зардалд 35634.2 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 20950.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 20950.0 мянган төгрөг, унааны зардалд 42500.0 мянган төгрөг, хууль тогтоомж сурталчилах зардалд 8000.0, санал авах байрны зардалд 17000.0 мянган төгрөг, саналын хуудас хүргэх зардалд 3296.0 мянган төгрөг, санал авах машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх зардалд 13401.6 мянган төгрөг, МТБ-ийн мэдээ дамжуулах зардалд 600.0 мянган төгрөг, томилолтын зардалд 7650.8 мянган төгрөг, эрчим хүчний эх үүсвэр бэлдэх зардалд 4165.0 мянган төгрөг, сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардалд 142240.4 мянган төгрөг, МТ-ийн сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардалд 27447.2 мянган төгрөг, болзошгүй зардалд 3000.0 мянган төгрөг, бичиг хэргийн ажилтан болон нягтлан бодогч нарын урамшуулал хоолны зардалд 1700.0 мянган төгрөг, төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх зардалд 600.0 мянган төгрөг зарцуулахаар төсөвлөсөн байна.

**Баян-Өлгий аймгийн 2016 оны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
сонгуулийн зардлын төсвийн гүйцэтгэл**

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт+ Хэмнэлт-
1	Саналын хуудас устгах зардал	1,000,000	1,000,000	-
2	Тогтоол протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250,000	250,000	-
3	Сургалтын зардал	35,634,200	31,084,575	-4,549,625
4	Бичиг хэргийн зардал	20,400,000	20,400,000	-
5	Шуудан холбооны зардал	20,950,000	20,950,000	-
6	Унааны зардал	42,500,000	42,500,000	-
7	Хууль тогтоомж сурталчлах зардал	8,000,000	5,350,000	-2,650,000
8	Санал авах байр бэлтгэх зардал	17,000,000	17,000,000	-
9	Саналын хуудас хүргэх зардал	3,296,000	3,296,000	-
10	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	13,401,600	12,401,600	-1,000,000
11	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	600,000	320,000	-280,000
12	Томилолтын зардал	7,650,800	7,650,800	-
13	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	4,165,000	4,165,000	-
14	сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	142,240,400	142,240,400	-
15	сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал /МТ/	27,447,200	27,447,200	-
16	Болзошгүй зардал	3,000,000	-	- 3,000,000
17	Бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч нарын урамшуулал, хоолны зардал	1,700,000	1,700,000	-
18	Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх зардал	600,000	600,000	-
	Нийт дүн	349,835,200	338,355,575	-11,479,625

Төсвийн гүйцэтгэлээр сургалтын зардлыг 4549.6 мянган төгрөгөөр, хууль тогтоомж сурталчлах зардлыг 2650.0 мянган төгрөгөөр, санал авах машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх зардлыг 1000.0 мянган төгрөгөөр, МТБ-ийн мэдээ дамжуулах зардлыг 280.0 мянган төгрөгөөр, болзошгүй зардлыг 3000.0 мянган төгрөгөөр хэмнэж бусад зардлуудыг төсөвт багтаан зориулалтын дагуу зарцуулжээ.

Аймгийн сонгуулийн хорооны даргын тушаалаар сонгуулийн зардлын төсвийг зардал тус бүрээр сумдын сонгуулийн хороодод хуваарилан санхүүжилтийг олгосон байна.

**Аймаг сумын сонгуулийн хороодын төсвийн хуваарилалт,
гүйцэтгэл**

№	Сумын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт+ Хэмнэлт-
1	Алтай	12,715,620	12,715,620	
2	Алтанцөгц	11,267,580	11,267,580	
3	Баяннуур	12,253,520	12,253,520	
4	Булган	19,121,240	19,121,240	
5	Бугат	9,244,680	9,244,680	
6	Буянт	10,911,020	10,911,020	
7	Дэлүүн	28,479,460	28,479,460	
8	Ногооннуур	20,414,480	20,414,480	
9	Толбо	15,492,500	15,492,500	
10	Улаанхус	20,759,340	20,759,340	
11	Сагсай	21,375,200	20,711,250	- 663,950
12	Цэнгэл	25,026,520	25,026,520	
13	Өлгий	34,516,880	34,516,880	
14	Аймгийн сонгуулийн хороо	108,257,160	97,441,485	- 10,815,675
	Аймгийн дүн	349,385,200	338,355,575	- 11,479,625

Сумын сонгуулийн хороодод 241128,0 мянган төгрөгийн төсөв хуваарилагдсаныг төсвийн зориулалтын дагуу зарцуулсан байна. Аймгийн сонгуулийн хороо төсвөө 10815.7 мянган төгрөгөөр, Сагсай сумын сонгуулийн хороо төсвөө 663.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Аймаг, сумын сонгуулийн хорооны гишүүд, мэдээлэл технологийн баг, даамлуудад олгосон урамшуулал, хоолны мөнгөнөөс нийтдээ 19527.1 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж аймгийн татварын хэлтэст шилжүүлсэн байна. Аймаг сумын сонгуулийн хороод нь зарцуулсан хөрөнгө, мөнгөний зарцуулалтын анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлж, тайлангаа гаргасан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- **Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зардлын төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулсан байна.**

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.БЕКЕН

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

ШИНЖЭЭЧ

Ж.НАЗГҮЛ

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ

ДАРГА

К.БАЙМУРАТ

НЯГТЛАН БОДОГЧ

Х.СЬЕЗД